



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 15 өдөр

Дугаар А/773.

Булган сум

Гамшгаас хамгаалах сургууллт, бэлэн байдлын үзлэг явуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 10.3.1-3, 10.3.5, 10.3.6, 32 дугаар зүйлийн 32.1.2, 32.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг дарга 2023 онд сумдын Засаг дарга нартай байгуулсан гэрээ, аймгийн Онцгой комиссын 2023 оны төлөвлөгөөний дагуу Хишиг-Өндөр суманд “Болзошгүй гамшгийн үед нутгийн удирдлагын үйл ажиллагаа” сэдвээр гамшгаас хамгаалах “Иж бүрэн” сургуулилтыг 2023 оны 11 дүгээр сарын 30, 12 дугаар сарын 01-ний өдрүүдэд Хангал суманд “Гамшиг ослын үе дэх сумын удирдлагын үйл ажиллагаа” сэдвээр “Команд штаб”-ын сургуулилтыг 2023 оны 12 дугаар сарын 06-07-ны өдрүүдэд Гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийг Рашаант суманд 12 дугаар сарын 29-ний өдөр Тэшиг суманд 12 дугаар сарын 05-ны өдрүүдэд тус тус зохион байгуулсугай.

2. Гамшгаас хамгаалах сургууллт, бэлэн байдлын үзлэгийн бэлтгэл ажлыг чанартай хангаж, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Хишиг-Өндөр (Н.Мөнхгэрэл), Хангал (М.Төмөрбат), Рашаант (Б.Бат-Эрдэнэ), Тэшиг (Ж.Гансүх) сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Гамшгаас хамгаалах сургууллт, бэлэн байдлын үзлэгт аймгийн Мал эмнэлгийн газар, Эрүүл мэндийн газар, сумын удирдах баг бүрэлдэхүүн, мэргэжлийн анги, гамшгаас хамгаалах албыг татан оролцуулж, мэргэжлийн туслалцаа үзүүлэн, удирдлага зохион байгуулалтаар хангаж, үр дүнтэй явуулахыг Онцгой байдлын газрын дарга (хурандаа Ш.Баасандорж)-д даалгасугай.

4. Гамшгаас хамгаалах “Иж бүрэн”, “Команд штаб”-ын сургууллт, бэлэн байдлын үзлэг зохион байгуулахад шаардагдах шатахууны зардал 895,500 (найман зуун ерэн таван мянга таван зуу) төгрөгийг гамшгийн эрсдлийг бууруулах арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Б.Бумцэнд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  Б.АРИУН-ЭРДЭНЭ

11 8223010000

Аймгийн Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын
15-ны өдрийн А/ТЗ дугаар захирамжийн хавсралт



**ГАМШГААС ХАМГААЛАХ СУРГУУЛИЛТ, БЭЛЭН БАЙДЛЫН ҮЗЛЭГ ЗОХИОН
БАЙГУУЛАХАД ШААРДЛАГАТАЙ ЗАРДЛЫН ТООЦОО**

Шатахууны зардал

д/д	Явах чиглэл	Туулах зай (км)	100км –т зарцуулах шатахуун (литр)	Шатахууны үнэ (төгрөг)
1	Булган-Рашаант	220	1120х20=225л (Лонг-78 автомашин 100км-т 20л түлш зарцуулна)	Дезиль түлш 225х3980=895,500
2	Рашаант-Хишиг-Өндөр	140		
3	Хишиг-Өндөр -Булган сум	80		
4	Булган сум-Тэшиг	240		
5	Тэшиг-Булган	240		
6	Булган-Хангал	100		
	Хангал -Булган	100		
Нийт		1120	225л	895,500